

ТАНИЛЦУУЛГА:

Олон улсын практикт үнэт цаасны зах зээлд учирч буй эрсдлүүдийг ерөнхийд нь зах зээлийн, хөрвөх чадварын, үйл ажиллагааны эрсдэл гэсэн гурван дэд бүлэгт хуваан судалдаг бөгөөд дээрх гурван эрсдлийн төрлийг хамтатган системийн эрсдэл гэж нэршиж байна.

Манай улсын үнэт цаасны зах зээлийн практикт “Монголын хөрөнгийн бирж” ХК-д шинээр МПТ системийг нэвтрүүлэх хүртэл үеүүдэд зах зээлийн болон үйл ажиллагааны эрсдлийн тооцоолол, зохицуулалт байхгүй байв.

Харин үйл ажиллагааны эрсдлийн чиглэлээр Хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 2.1.3 дахь заалтаар буюу зохицуулалттай этгээдийн эрсдлийн сангийн харилцааг хэт ерөнхий байдлаар зохицуулсан шинжтэй байв.

“Монголын хөрөнгийн бирж” ХК-д шинээр нэвтрүүлсэн МПТ системийн хүрээнд системийн эрсдлээс урьдчилан сэргийлэх, учирсан нөхцөлд системийн хэмжээний эрсдэл үүсэхгүй байх үүднээс “ҮЦТТТХТ” ХХК-ийн “Т+3 журам” болон “Төлбөрийн баталгааны сангийн түр журмуудаар” тус тус зах зээлийн эрсдлийн харилцааг нарийвчлан зохицуулж байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу Хороо зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны эрсдлийн сангийн журмын батлан мөрдүүлэх эрх зүйн зохицуулалт бий болсон.

“Зохицуулалттай этгээдийн эрсдлийн сангийн тухай журам”-ыг үнэт цаасны зах зээлийн зуучлагч байгууллагуудын арга зүйн дараахь онцлог шинжүүдийн хүрээнд боловсруулсан. Үүнд:

- Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээт нь Банк, Даатгал, Банк бус санхүүгийн байгууллагаас эрсдлийн зохицуулалтын хувьд дөрвөн онцлог ялгаатай.
 1. Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдүүд нь харилцагчийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөс тусад нь буюу “off balance”-д тусгадаг;
 2. Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдүүд нь бусад этгээдүүдээс хадгаламжийн эх үүсвэр татаж эх үүсвэрээ бүрдүүлдэггүй тул өөрийн харилцагчийн өмнө хүлээх хариуцлага нь бусад санхүүгийн оролцогчдоос эрс бага;
 3. Зохицуулалттай этгээд нь үнэт цаасны зах зээлд харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар үнэт цаасны арилжаанд оролцож, харилцагчийн захиалгыг гүйцэтгэдэг тул зах зээлийн болон хөрвөх чадварын эрсдэлд ихээхэн өртөмтгий шинжтэй;
 4. Үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, хадгаламж, зуучлалын үйл ажиллагааг бие даасан байгууллагууд эрхэлдэг.

Дээрх арга зүйн онцлог шинжүүдийн хүрээнд үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны эрсдлийг “эрсдлийн сангийн журам”-аар зах зээлийн эрсдлийн зохицуулалтыг “ҮЦТТТХТ” ХХК-ийн “Үнэт цаасны төлбөр тооцоог Т+3

хугацаанд гүйцэтгэх журам” болон “Төлбөрийн баталгааны сангийн журам”-уудаар тус тус нарийвчлан зохицуулагдах юм.

“Зохицуулалттай этгээдийн эрсдлийн сангийн журам”-аар эрсдлийн санг байгуулах, нөхөн бүрдүүлэх, сангийн хөрөнгийн бүртгэл, үйл ажиллагааны эрсдлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, сангийн хөрөнгийг захиран зарцуулах эрх үүргийн харилцааг зохицуулсан.

Дээрх журам батлагдан гарснаар зохицуулалттай этгээдүүдийн үйл ажиллагааны эрсдлийн харилцааг цогц байдлаар зохицуулан, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, харилцагчдад учруулсан хохирлыг нөхөн барагдуулах нөхцөл бүрдэнэ.

**ҮНЭТ ЦААСНЫ ГАЗАР
МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ХЭЛТЭС**

ТӨСӨӨЛ

ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДИЙН ЭРСДЛИЙН САНГИЙН ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмаар Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд, түүний албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас харилцагч, хөрөнгө оруулагчдад учруулсан хохирлыг нөхөн барагдуулах зорилгоор эрсдлийн санг бүрдүүлэх, хадгалах, ашиглах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулана.

1.2. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1. “зохицуулалттай этгээд” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх компанийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг;

1.2.2. “зохицуулалттай этгээдийн албан тушаалтан” гэж зохицуулалттай этгээдийн харилцагч, хөрөнгө оруулагчтай харилцдаг албан тушаалтан болон түүний удирдах албан тушаалтныг;

1.2.3. “брокерийн үйл ажиллагаа” гэж харилцагчийн хөрөнгөөр, түүний нэрийн өмнөөс, түүний даалгавраар үнэт цаасыг худалдах, худалдан авахтай холбоотой зуучлалын үйлчилгээг гэрээний үндсэн дээр эрхлэхийг;

1.2.3. “дилерийн үйл ажиллагаа” гэж өөрийн нэрийн өмнөөс өөрийн хөрөнгөөр үнэт цаасыг худалдах, худалдан авах ажиллагаа эрхлэхийг;

1.2.4. “андеррайтерийн үйл ажиллагаа” гэж үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр түүний үнэт цаасыг нийтэд санал болгон гаргахад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, үнэт цаас гаргагчийн үнэт цаасны анхдагч зах зээлд худалдагдаагүй үлдсэн үнэт цаасыг андеррайтерийн гэрээнд заасан хэмжээгээр худалдаж авах зэрэг ажиллагаа эрхлэхийг;

1.2.5. “хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа” гэж үнэт цаас гаргагчийн нийтэд танилцуулагдсан мэдээлэл дээр үндэслэн судалгаа, шинжилгээг гүйцэтгэх, харилцагчид үнэт цаасыг худалдах, худалдан авах үнэ, нөхцөл, хугацааны талаар мэргэжлийн зөвлөгөөг төлбөртэйгөөр өгөх ажиллагаа эрхлэхийг;

1.2.6. “Үйл ажиллагааны эрсдэл” гэж тухайн компанийн дотоод үйл ажиллагаатай холбоотой ажилтны санаатай болон болгоомжгүй үйлдэл, дотоод хяналтын тогтолцооны алдааг.

Хоёр: ЭРСДЛЭЭС ХАМГААЛАХ САНГ БАЙГУУЛАХ

2.1. Хорооноос үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, Арилжаа эрхлэх байгууллагын гишүүнчлэл бүхий зохицуулалттай этгээд нь өөрсдийн харилцагч, хөрөнгө оруулагчдыг болзошгүй эрсдлээс хамгаалах зорилгоор үйл ажиллагааны эрсдлийн сантай байна.

2.2. Брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн компани нь үйл ажиллагааны эрсдлээс хамгаалах санг Хорооны “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 2.9-д заасны дагуу компанийн

өөрийн хөрөнгийн 3-аас доошгүй хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгөөр байгуулна. /эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгийн дээд хэмжээ нь 30.0 сая төгрөгөөс хэтрэхгүй байна.

2.3. Журмын 2.2-д заасан үйл ажиллагааны эрсдлийн сангийн мөнгөн хөрөнгийг арилжааны банкинд тусгайлсан данс нээж, тогтмол байршуулах бөгөөд сангийн үлдэгдлийг улирал тутам санхүүгийн тайлангийн хамт Хороонд хүргүүлнэ.

2.4. Компанийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон ашиг, хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр эрсдлийн сангийн хөрөнгийг нэмэгдүүлж болох ба үйл ажиллагааны эрсдлийн сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх эх үүсвэрийн тооцоолол, үндэслэлийг гүйцэтгэх захирлын өргөн мэдүүлснээр компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр баталгаажна.

2.5. Үйл ажиллагааны эрсдлийн сангийн хөрөнгийг зөвхөн компани, түүний албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас харилцагчдад учирсан хохирлыг барагдуулахад зарцуулах бөгөөд компани өөрөө барагдуулж болох ба Хорооны Улсын байцаагчийн албан шаардлагаар үүрэг өгсөн тохиолдолд ажлын 5 хоногийн дотор барагдуулна.

ГУРАВ: ЭРСДЛИЙН САНГИЙН БҮРТГЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР АВАХ АРГА ХЭМЖЭЭ

3.1. Эрсдлээс хамгаалах сангийн хөрөнгийг Хорооны нягтлан бодох бүртгэлийн үлгэрчилсэн зааврын дагуу эрсдэл тус бүрээр нэрийн данс нээж, балансын активын эргэлтийн хөрөнгө хэсэгт бүртгэнэ.

3.2. Зохицуулалттай этгээд нь үйл ажиллагааны эрсдлийг бууруулах чиглэлээр дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.2.1. Компанийн 3 жилийн бизнес төлөвлөгөөнд үйл ажиллагааны эрсдлийн талаар тусгаж, түүнээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөх;

3.2.2. Компанийн дотоод хяналтын ажилтны үүрэг, хариуцлагыг дээшлүүлж, үр ашигтай хяналтын тогтолцоог бүрдүүлэх, ажлын сахиалга, хариуцлагыг дотоод хяналтын журмаар нарийвчлан зохицуулж, түүнийг мөрдүүлэх чиглэлээр компанийн удирдлагаас байнга анхаарах;

3.2.3. Компанийн удирдлагаас ажилтнуудынхаа үнэт цаасны зах зээлийн талаарх мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах.

3.3. Компанийн дотоод хяналтын ажилтан нь үйл ажиллагааны эрсдлийн сангийн хөрөнгийн бүртгэл хөтлөлт, хяналт зохицуулалтыг зохион байгуулна.

ДӨРӨВ: ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЛИЙН САНГ ЗАХИРАН ЗАРЦУУЛАХ, САНГИЙН ХӨРӨНГИЙГ НӨХӨН БАЙРШУУЛАХ

4.1. Үйл ажиллагааны эрсдлийн сангийн хөрөнгийг энэхүү журамд зааснаас зорилгоор зарцуулах, ашиглахыг хатуу хориглоно.

4.2. Харилцагч нь зохицуулалттай этгээдийн буруутай үйл ажиллгааны улмаас эрх нь зөрчигдсөн гэж үзвэл зохицуулалттай этгээдийн удирдах албан тушаалтанд, шаардлагатай гэж үзвэл Хороонд хандаж өргөдөл гаргана.

4.4. Харилцагчийн өргөдлийг компанийн дотоод хяналтын ажилтан хүлээн авч хянаад, өөрийн компанийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн харилцагчид хохирол учруулсан гэж үзвэл гүйцэтгэх удирдлагад танилцуулан холбогдох арга хэмжээг цаг тухайд авч хэрэгжүүлнэ.

4.5. Журмын 4.4-д заасан арга хэмжээ, Хорооны Улсын байцаагчийн албан шаардлагаар үйл ажиллагааны эрсдлийн сангаас харилцагчид учирсан хохирлыг барагдуулсан нөхцөлд нэн даруй Хороонд мэдэгдэж, сангийн хөрөнгийг нөхөн бүрдүүлж, энэ талаарх холбогдох баримтыг Хороонд ирүүлнэ.

4.6. Журмын 4.5-д заасан нөхцөл үүсч, үйл ажиллагааны эрсдлийн сангийн мөнгөн хөрөнгө энэхү журамд заасан хэмжээнээс багассан тохиолдолд ажлын 5 хоногийн дотор тогтоосон хэмжээнд нөхөн бүрдүүлнэ.

4.7. Улсын байцаагчийн албан шаардлагаар хохирол барагдуулах үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй, эсхүл сангийн хөрөнгийг энэхүү журмын 4.6-д заасан хугацаанд нөхөн байршуулаагүй тохиолдолд брокер, дилерийн компанийн үнэт цаасны арилжаанд орох эрхийг түр хугацаагаар зогсоож, зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх асуудлыг Хорооны хуралдаанаар хэлэлцүүлнэ.

ТАВ: ХАРИУЦЛАГА

5.1. Энхүү журмын холбогдох заалтыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан захиргааны хариуцлага хүлээлгэх бөгөөд захиргааны шийтгэлтэйд тооцогдох хугацаанд дахин зөрчил гаргасан тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг Хорооны хуралдаанд хэлэлцүүлнэ.